# БАЯНХОНГОР АЙМГИЙН
# ШИНЭЖИНСТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
# ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 25 өдөр Дугаар А/02 Залаа

Захирамжаар өмчлүүлсэн газрын
хэмжээ залруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугээр зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1 дэх заалт, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын хуралдааны 2022 оны 63 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар өөрийн эзэмшил газраа өмчлөх явцад хэмжилтийн алдаанаас шалтгаалж талбайн хэмжээ зөрүүтэй гарсан 1 иргэний өмчлөлийн газрын хэмжээг хавсралтаар залруулсугай.

2.Холбогдох хууль тогтоомжид заасан хүрээнд өмчлөх эрхээ хэрэгжүүлэхийг газар өмчлөгчдөд, иргэний өмчилсөн газрын хил заагийг газар дээр нь тэмдэгжүүлж, хүлээлгэн өгөх, газрын улсын бүртгэлд бүртгэх ажлыг зохион байгуулж, газар өмчлөгчийг хуулийн дагуу хүлээсэн үүргээ биелүүлэхэд хяналт тавьж ажиллахыг газрын даамал (У.Мөнхнаран)-д үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын орлогч (Н.Бямбадорж)-д даалгасугай.

4.Захирамжийн хавсралтад орсон иргэдийн анхны өмчлөлийн захирамжийн иргэнтэй холбогдох хэсгийн талбайн хэмжээг хүчингүй болгосугай.

ДАРГА Б.БАТ-ЭРДЭНЭ

642301139

F:\2023\ZD\Zahiramj.docx

Сумын Засаг даргын 2024 оны 01 дүгээр
сарын 25-ны өдрийн А/02 дугаар
захирамжийн хавсралт

# ЗАХИРАМЖААР ӨМЧЛҮҮЛСЭН ГАЗРЫН ХЭМЖЭЭ ЗАЛРУУЛСАН НЭГЖ ТАЛБАРЫН МЭДЭЭЛЭЛ

| д/д | Газар өмчлөгчийн | | | Өмнөх | | | | | | Шинээр үүсэх | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Захирамжийн | | Газрын | | | | | | | | |
| | | | | | | | | Хаяг | | | | | | |
| | Эцэг /эх/-ийн нэр | Нэр | Регистрийн дугаар | огноо | Дугаар | Нэгж талбарын дугаар | хэмжээ /м2/ | Баг | Байршил | Өөрчлөлт оруулах газрын хэмжээ /м2/ | Нийт талбайн хэмжээ /м2/ | Нэгж талбарын дугаар | Байршил | Газрын зориулалт /тайлбар/ |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 | 14 | 15 |
| 1 | Базаррагчаа | Баатаржав | ХК69022717 | 2013.12.20 | 118 | 6419000270 | 839 | Эхэн-хавцгай 4-р баг | 4 гудамж 1 тоот | 65 | 904 | 6419001259 | Өндөрлөг 4-401 | ГБХ |

____________оОо____________